

# The Baptist Tabernacle of Los Angeles

1329 South Hope Street, L.A. Civic Center

Mailing Address:  
P. O. Box 15308  
Los Angeles, CA 90015  
Phone: (213) 744-9999

E-mail: [rlhymersjr@sbcglobal.net](mailto:rlhymersjr@sbcglobal.net)  
[www.sermonsfortheworld.com](http://www.sermonsfortheworld.com)  
[www.baptisttabernacle.com](http://www.baptisttabernacle.com)



Dr. R. L. Hymers, Jr.  
Senior Pastor

Dr. Christopher L. Cagan  
Associate Pastor

Арван хоёрдугаар сар, 2018

Эрхэм анд минь:

Энэ оны дөрөвдүгээр сард хэвлэгдсэн “Бүх л айдсын эсрэг” ном бол миний амьдралын түүх юм. Миний номыг сайшааж буй хүмүүсээс Др Боб Жонс III намайг “эш үзүүлэгч” хэмээн нэрлэсэн. ВВФИ-ийн захирлаар хоёронтоо сонгогдсон Др Билл Монрое “Химерс бол орчин цагийн Даниел” гэж хэлсэн. ВВФИ-ийг үүсгэн байгуулагч Ровлинг Сангийн тэргүүн Др Жон Ровлинг намайг “Жинхэнэ Америк хүн! Алсыг харагч! Түүний амьдрал нь өөрчлөлтийг буй болгодог тэвчээрийн үлгэр жишээ” гэж хэлсэн. Сонингын эрхлэгч Др Дон Бойс “Бүх л айдсын эсрэг” ном нь зөвхөн номлогч нар бус, харин бүх хүн унших хэрэгтэй ном. Химерс бол хүн бүрд үлгэр жишээ... Түүний намтар өнөө цагийн хэрэгцээг багцалдаг – эр зориг, чин үнэнч байдал, нэр хүнд.”

Ийм маягаар эдгээр алдартай Христ итгэгч нар миний талаар хэлсэн зүйлсийг сонсоод заримдаа би яаж ийм юм байж болох вэ хэмээн гайхдаг. Би үргэлж л “Би яаж яваад ийм болчихсон юм болоо?” хэмээн гайхдаг. Би номлогч болохоор дуудагдахаас өмнө миний үйлчлэлийн эхэнд Бурхан надад миний амьдралын эшлэлийг өгсөн,

“Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна.”  
(Филиппой 4:13)

Би 61 жилийн турш энэ амлалт нь үнэн болохыг биеэрээ туулж мэдсэн. Би бүх л амьдралынхаа туршид олон төрлийн сорилт бэрхшээлийг туулж ирсэн. Би үргэлж Есүс Христэд бүрэн тулгуурлаж байсан учраас тулаан бүрдээ ялалтыг байгуулж ирсэн. Христийн улмаас би маш их саад бэрхшээлийг давж, дэлхий даяарх олон сая хүмүүсийг урамшуулагч болсон юм. Би Есүс Христэд бүрэн тулгуурлаж байсан учраас тулаан бүрдээ ялалтыг байгуулж ирсэн.

Эдгээр нь “том” тулаануудын ердөө л хэдэн жишээ нь. Би Бичээсийг муучилдаг байсан библийн сургуулийнхаа худал сургаалын эсрэг зогсох хэрэгтэй байсан учраас Библийн алдаа мадаггүй байдлын төлөө тулалдаж байсан. Би бүрэн Христэд тулгуурлаж байсан учраас тулаандаа ялалт байгуулсан. Дараа нь би “Христийн Сүүлчийн Сорилт” нэртэй Есүс Магдалын Мариатай сексийн харилцаанд орсон хэмээн харуулсан маш их гутаан доромжилсон киноны эсрэг тулаанд орж байсан. Би бүрэн Христэд тулгуурлаж байсан учраас тулаандаа ялалт байгуулсан. Телевиз болон радиогын “худал” үзэл суртлаар намайг Иудейчүүдийн эсрэг үзэлтэн мэтээр буруутгаж байсан. Би Есүс Христэд, зөвхөн Түүнд түшиглэж байсан учраас энэ ялаас бүрэн цагаадаж, уг тулаандаа ялалт байгуулсан. Дахиад дараа нь үр хөндөлтийн эсрэг тулаан болсон. Миний туслах Рев Жон Самуел Каган “Др Химерс үр хөндөлтийн хоёр эмнэлгийг хаалгуулахаар олон нийтийг хамарсан цугларалтад

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 40 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН  
НОМЛОЛУУДЫГ [WWW.SERMONSFORTHEWORLD.COM](http://WWW.SERMONSFORTHEWORLD.COM)-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**

бүх чуулганаа уриалан оролцсон. Тэрээр уг хоёр эмнэлэг бүрэн хаагдах хүртэл нь тэмцлээ үргэлжлүүлсэн” хэмээн хэлсэн. Би Есүстэй хамт байсан бөгөөд бид бүрэн Христэд түшиглэсэн учраас тулаандаа ялалт байгуулсан. Тэгээд мөн манай чуулганы байрыг аврах тулаанд орсон. Хорон муу нүгэлт нэгэн манай гишүүдийн 320 хүнийг аваад явсан, тэгээд бид бараг л чуулганахаа байрыг алдахад хүрсэн. Энэ тулаанд ч гэсэн бид ялах боломжтой байсан нь “Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна.” гэсэн итгэлийн улмаас юм. Иймэрхүү тулаанд орох үедээ би аль нь сайн хийгээд аль нь муу болохыг юуны түрүүнд тодорхойлдог байсан. Тэгээд би зөв талаар нь шийдэж байсан бөгөөд “Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна.” гэсэн итгэлийн улмаас юм.

Энэ үед олон чуулган бусад чуулганы гишүүдийг хулгайлаад өөрсдийнхөө чуулганыг босгохоор оролдож байх тэр үед би дэлхийгээс алдагдсан хүмүүсийг олох боломжтой учраас тэгэх ямар ч шаардлага байгаагүй. Яагаад? Учир нь “Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна.” Ийм л учраас тэр юм! Ийм л учраас бид бүх дэлхий даяар Сайнмэдээг хүргэх тулаанд ялалт байгуулж чадсан юм. Өнөөдөр дэлхий даяар 221 улсад манай вебсайтаар дамжуулан 40 хэл дээр 1,5 сая хүн миний номлолыг уншиж байна - Учир нь “Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна.”

Рев. Жон Каган ийнхүү хэлсэн, “Др Химерс урт удаан туршлагаараа хэн нэгний амьдралыг босгон байгуулах цорын ганц суурь бол хүн болох Христ Есүс – Хадан Суурь нь гэдгийг мэддэг.”

Миний хүү Роберт ийнхүү хэлсэн, “Миний аавыг маш цөөхөн хүмүүс л ойлгодог, учир нь тэр бусад энгийн хүмүүс шиг сэтгэдгүй юм. Тэр Бурхантай хамт алхаж байдаг.” Би тулаан бүрдээ ялалтаа мандуулж байсан нь нэг л шалтгааны улмаас байдаг нь - “Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна.” Ийм л учраас бидний энэ чуулган оршин тогтнож байгаа. Ийм л учраас миний номлолоор аврагдсан тэдгээр хүмүүсээс би босоорой хэмээн хүсэхэд бараг бүгд босдог. Ердөө хоёр хүн л өөр газарт авралыг олсон байдаг.

Миний итгэмжит хамтрагч, анд минь болох Др Кристофер Л.Каган ийнхүү хэлсэн, “Др Химерс Есүс Христ хүмүүст ч гэсэн адилхан тусалж чадна гэдгийг харуулахаар өөрийгөө босгон байгуулаад, энэ их саадыг даван туулахаар саад бэрхшээлтэй тулгарч, нугарч, хугарч, шархадсан тийм нэгэн эр хүн юм.”

Др Эди Пурванто ийнхүү хэлсэн, “Хүн Бурхантай хамт байхад ялагдана гэдэг боломжгүй юм.”

Др Роберт Л.Сумнер, “Би үнэний төлөө зогсохыг хүсдэг, хэдий бүх л нөхцөл байдал түүний эсрэг байсан ч гэсэн тэгдэг хүмүүсийг би хүндэтгэн дээдэлдэг. Роберт Лесли Химерс Жр бол ийм төрлийн Христ итгэгчдийн нэг нь юм.”

Др Кенти Филпотт ийнхүү хэлсэн, “Др Химерс бол бидний хэн нь ч урьд хожид сонсож байгаагүй ухаалаг ‘хуучин цагийн залуу’ шилдэг номлогч байсан юм. Түүний анхаарал үргэлж Христийн үгэн [дээр] төвлөрч байдаг.”

Др Нийл Вейвер ийнхүү хэлсэн, “Др Химерс бол хүчирхэг итгэл үнэмшилтэй урам зоригтой эр хүн бөгөөд эдгээр итгэл үнэмшлийнхээ төлөө дайснуудын эсрэг тулалдахад [бэлэн] байдаг.”

Др Фил Гобле ийнхүү хэлсэн, “...орчин цагийн гладиатор дэлхийтэй тулалдахаар гарахдаа энэ агуу шилдэг номлогчийг дагаарай, яг түүн шиг итгэлийн сайн тэмцлээр тэмцээрэй.”

Др Кристофер Л.Каган ийнхүү хэлсэн, “Др Р.Л Химерс Жр бол бүх л айдсын эсрэг – боломжгүй зүйлсийг боломжтой болгосж байсан! Би дөчин жилийн турш түүнтэй ойрхон ажиллаж байгаа учраас үүнийг мэдэж байна.”

Та миний намтарыг бичсэн “Бүх л айдсын эсрэг” номыг ердөө 10 доллароор худалдан

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 40 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН  
НОМЛОЛУУДЫГ [WWW.SERMONSFORTHEWORLD.COM](http://WWW.SERMONSFORTHEWORLD.COM)-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**

авч болно. Др С.Л Каган руу P.O. Box 15308, Los Angeles, California 90015 гэсэн хаягаар бичиж болно. ТӨЛБӨРИЙН УТГА ДЭЭРЭЭ “ХРИСТМАС ЗАХИА” ГЭСЭН ҮГСИЙГ БИЧЭЭД 10 ДОЛЛАРЫН ХӨНГӨЛӨЛТ АВЧ БОЛНО ГЭДЭГТЭЭ ИТГЭЛТЭЙ БАЙЖ БОЛНО. Ердөө 10 доллар шилжүүлээд миний амьдралын түүхийн талаар бичсэн номыг аваарай!

Таныг Христмасын үеэр Бурхан ерөөхийн төлөө би залбирах болно. Мөн Шинэ Жилээр ч гэсэн Эзэн таныг ивээх болтугай! Есүс Христ магтагдах болтугай!



Др Химерс эхнэр Илеанагын хамт, түүний хүү Роберт, Робертын гэргий Жин, Робертын хоёр охин Ханна болон Сара нарын хамт.

Есүсийн нэрээр мэндчилсэн,

Р.Л Химерс Жр.,  
D.Min., Th.D., Litt.D.  
Филиппой 4:13



Химерсын гэр бүл хатагтай Химерсийн нагац ах Франциско Кастро, Каролина, Бриана, Гватемалагаас ирсэн Ервин Цуеллар, Антониа нарын хамт.



Др Химерс, түүний гэргий нар Хөдөлмөрчдийн өдрийн амралтын өдөрт Библийн конференцээр заасан Др Елмер Л. Товнсын хамт.

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 40 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН НОМЛОЛУУДЫГ [WWW.SERMONSFORTHEWORLD.COM](http://WWW.SERMONSFORTHEWORLD.COM)-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**